

ТҮР ХОРОГДОХ БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Г.ГАЛБАДРАХ

ДХИС-ийн АШБС-ийн “Гамшиг судлал”-ын магистрант

Хураангуй

Нийгэм болон хувь хүний эрүүл аюулгүй байх эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн байр орон сууц, барилгад тавигдах тодорхой норм дүрмүүд байдаг.

Дээрх норм дүрэм, стандартад нийцсэн барилга байгууламжууд баригдахын зэрэгцээ зарим гамшиг ослын үед зориулалтыг өөрчлөн өөр шаардлагаар ашиглахаар тооцон төлөвлөж байгаа нь орчин үеийн түр хорогдох байрны нэг хэлбэр юм.


Гэнэтийн осол, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр үүссэн аюулт үзэгдлийн хохирлыг бууруулах чиглэлээр улс орон, бүс нутгийн хэмжээнд тодорхой арга хэмжээнүүдийг авсаар ирсэн. Үүний нэг нь түр хорогдох байранд тавигдах тодорхой шаардлагууд, боломж бололцоог сайжруулсаар ирсэн байна. Шинэлэг технологи, шинэ арга барил, технологийг боловсруулан үйл ажиллагаандаа тусгаж ажиллах нь Онцгой байдлын байгууллагын өмнө тавигдаж буй чухал зорилт мөн билээ. Бусад улс орнуудад хэрэгжиж буй бодит жишээнүүдэд харьцуулсан судалгаа хийж манай орны цаг уур, газар нутгийн онцлог, соёл зэрэгт тулгуурлан боломжит хувилбарыг бий болгож гамшгийн үед ашиглахаар төлөвлөх хэрэгтэй.

Түлхүүр үг: Нүүлгэн шилжүүлэлт, түр байр, түр байранд тавигдах шаардлага

Удиртгал

Түр хорогдох байрыг ярихын өмнө тухайн байр нь хаана байрлах, газар нутаг хүн амын соёл, иргэдийг хэрхэн зөөвөрлөх, ямар үед түр хорогдох байрыг ашиглах, түр байрны хүчин чадал нөөц бололцоо, ашиглагдах технологийн тухай тодорхой ойлголттой болох нь түр хорогдох байрны салшгүй нэг зүйл юм.

Загвар 1. Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл.



хойшлуулшгүй нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Энэ үед онцгой байдлын бүсээс хүн амыг богино хугацаанд амжиж гаргана.

Хүснэгт №1. Нүүлгэн шилжүүлэх шалгуур үзүүлэлт¹.

Балл	Газар хөдлөлтийн хүч	Балл	Эвдрэл	Хүмүүс, барилга байгууламж, байгаль орчинд нөлөөлөх шинж төрх байдал, товч тодорхойлолт	Шалгуур үзүүлэлт
1	Хөрс үл мэдэгдэх ээр хөдлөх		гэмтэл	Зөвхөн газар хөдлөлтийн багаж мэдэрнэ	
2	Маш сул түлхэлт		эвдрэл	Багаж мэдэрнэ. Тайван байдалд байгаа зарим хүч мэдэрнэ.	Урьдчилан сэргийлэх ажил хийгдэнэ.
3	Сул		зэргийн	Чийдэнгийн шил, онгорхой хаалга бага зэрэг ганхана, хүн амын цөөхөн хэсэг нь мэдэрнэ.	
4	Мэдэгдэм	2-3-4 балл	сул	Цонхны шил доргиж дуугарах, хана, хаалга шажигнана.	
5	Хүчтэйвтэр		бага I зэрэг хөнгөн гэмтэл	Гадаа ихэнх хүн, дотор (гэр, байшин) бүх хүн мэдэрнэ. Байшин ерөнхийдөө хөдөлж, тавилга ганхана. Цагийн дүүжин зогсоно. Цонхны шил, байшингийн шавардлага хагарна.	Хяналт үнэлгээний ажил хийгдэнэ.
6	Хүчтэй	5-6 балл	Дунд II зэрэг	Бүх хүн мэдэрнэ. Хананд өлгөөстэй зүйлүүд унана. Шавардлага ховхорч унана.	
7	Иххүчтэй	7-8 балл	Хүчтэй III зэрэг хүнд гэмтэл	Өлгөөстэй зүйлүүд хүчтэй савлана. Тавилга байрнаасаа хөдөлнө. Чулуун байшингийн хананд ан цавгарна. Газар хөдлөлийн тооцоотой барьсан байшин, модон байшин зүгээр үлдэнэ. Голын эргүүд нурна.	Аврах ажил хийгдэнэ.
8	Эвдлэн сүйтгэх	7-8 балл	Иххүчтэй III зэрэг хүнд	Эгц уруу газар, чийгтэй хөрсөнд ан цавгарна. Хөшөөнүүд байрнаасаа хөдлөх буюу унана, байшин хүчтэй гэмтэнэ.	Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэнэ.
9	Цөлмөн сүйтгэх	9-10 балл	Машхүчтэй IV зэрэг ноцтой	Чулуун байшингууд хүчтэй эвдэрч нурна. Хуучин модон байшингууд хазайж муруйна.	Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэнэ.

10	Устг н сүйтг эх	9-10 балл	эвдрэл V зэргийн	Хөрсөнд 1м хүртэл өргөнтэй ан цав гарна. Зам эвдэрнэ. Уулнаас нуралт үүснэ. Мөн шавар гулсана (урсана). Чулуун барилгууд нурна. Труба хоолойнууд тасарч, мод хугарна	Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэнэ.
11	Егүүтг эн сүйтгэ х	11-12 балл	Бүрэн	Газрын гадаргуу дээр өргөн ан цав гарна. Нуралт (гулсалт, мөлхөлт) үүснэ. Чулуун барилгууд бүрэн нурна. Төмөр замын рельс тахийж гулзайн нумарна.	Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэнэ.
12	Аюул т егүүтг эл	11-12 балл		Газрын хөрсөнд асар их өөрчлөлт орно. Олон ан цавгарч (газархагарч) нуралт, хөрсний мөлхөлт үүснэ. Шинээр хүрхрээ, нуур, цөөрмүүд үүсч, голын урсгалын сав өөрчлөгдөнө. Ямарч барилга байшин бүрэн үлдэхгүй. Ургамал, амьтан нурангид дарагдаж сөнөнө.	Нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэнэ.


Хүснэгтээс үзэхэд 8 буюу түүнээс дээш баллын газар хөдлөлтийн үед тухайн хот, суурин газрын хүн амыг нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлага үүсч байгаа нь харагдаж байна.

Нүүлгэн шилжүүлэлтийн явуулах арга.

Нүүлгэн шилжүүлэлтийн хугацааг багасгах гол арга бол хосолсон аргаар хүмүүсийг гаргах арга юм. Хосолсон аргаар нүүлгэн шилжүүлэлт хийхдээ хотоос хүн амын заримыг нь явганаар, зарим хэсгийг тээврийн хэрэгсэл ашиглаж гаргана.

Нүүлгэн шилжүүлэлтийг явуулахдаа тээврийн хэрэгслээр, явганаар, хосолсон байдлаар гүйцэтгэж болно.

Загвар 2. Нүүлгэн шилжүүлэх арга



Тайлбар: Судалгаачийн судалгааны ажил



Социализмын үед тухайн үед үүсч болох нөхцөл байдалд тулгуурлан тодорхой хэмжээний хорогдох байр нөөц бүрдүүлэлт хийгдэж байсан. Харин бид өнөөдөр байгалийн болзошгүй гамшгийн өмнө бэлтгэлтэй байх, хариу арга хэмжээг зохион байгуулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд шаардагдах зүйлсийн чадавхыг сайжруулах нь нэн тэргүүний тулгамдсан ажил болоод байна.

Түр байрны удирдах байгууллагын түвшинд тавигдах шаардлага.

Б.Түр байр: (хоргодох байр)

Түр байрыг удирдах нь олон талтай, өргөн хүрээтэй ихээхэн хүч сорьсон ажил юм. Түр байранд байрлах хүмүүстэй маш сайн харилцаа тогтоож, тэдэнд маргаашийн амьдралд итгэх итгэлийг төрүүлэхийн тулд тэдний хэрэгцээг хангахаас хавьгүй ихийг хийх хэрэгтэй. Хүмүүсийн туршлага, мэдлэгийг үнэлэн ашиглаж тэдэнд тэгш боломж, аюулгүй нөхцөл хамгаалагдсан орчин бүрдүүлж өгөх үүрэгтэй. Түр байрыг удирдах байгууллага, бүх үйлчилгээ иж бүрэн байх, үйлчлэх хүмүүсийн бие бялдар, сэтгэл санаа, соёл, зан заншил сэтгэл зүй зэргийг иж бүрнээр нь анхаарах ёстой. Түр байранд үйл ажиллагаа явуулж буй бүх хамтрагчдын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Түр байрыг удирдах байгууллага нь тэнд байрлаж буй хүмүүсийг хамгаалах, тэдэнд тусламж үйлчилгээ хүргэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна,
2. Түр байрлуулах байр байгуулах нь зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшгийн улмаас гэр орноо орхин дайжсан хүмүүсийг хамгаалан туслах хамгийн цогц арга хэмжээ байх ёстой,
3. Түр байрыг удирдах байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт нь олон улсын үйлчилгээний стандартыг хангаж байх ёстой,
4. Хүн бүрд тэгш хандах, үйлчилгээг жигд хүртээх үүднээс үйл ажиллагааны зохицуулалт хийх, мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэх системийг хамтрагч талуудтай хамтран боловсруулсан байх шаардлагатай,
5. Үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, удирдлагад хүмүүсийг оролцуулах, тэдний санаа бодлыг сонсох боломжийг бүрдүүлсэн байна.
6. Мэдээллийг цуглуулах, шинэчлэх түгээх, ашиглах систем хэрэгжсэн байна, Хүний хувийн нууцыг хадгална.
7. Тусгай хэрэгцээтэй болон онцгой эрсдэлд буй хүмүүсийн хэрэгцээг харгалзсан үйлчилгээ үзүүлнэ,
8. Түр байранд байрлаж буй иргэд, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, салбар болон кластерын байгууллага, засаг захиргааны байгууллага хоорондын харилцан итгэлцсэн, ил тод, бие биенээ дэмжсэн, бүгдийг оролцуулсан харилцаа хамтын ажиллагааг бий болгоно,
9. Түр байрыг удирдах байгууллагын хамгийн гол зорилго нь түр байранд байрлаж буй хүмүүсийн амьдралын стандартыг сайжруулах, хүний эрхийг хамгаалах юм,
10. Түр байрыг удирдах байгууллага өөрийн шийдэж чадахгүй аливаа асуудлыг салбарын эсвэл кластерын баг руу зуучлан хандуулах хэрэгтэй.

Түр байранд тавигдах шаардлага.

“Түр байр” гэж гамшигт өртөж болох нөлөөллийг бууруулах, хүн амыг хамгаалах зориулалтаар тогтоон тохижуулсан хүн амьдрах нөхцөл бүхий томилгоожуулсан нүүлгэн шилжүүлэх байршилд барьсан майхан (гэр).

1. Түр байрны загвар болон материал нь тухайн газрын онцлог, соёл нийгэм зэрэгтэй тохирохуйц байх,

2. Гэмтэж нурсан байр болон өвчтэй хүмүүсд анхны туслалцаа үзүүлэх зэрэг нь эхэлж хийгдэх,
3. Түр байрыг бэлдэхэд шаардагдсан сонгох материал нь өвчтэй хүмүүст тохирхоор бат бөх эдэлгээ сайтай байх
4. Барилгын загвар материал, хэмжээ, хаалганы байрлал нь тохилог дулаан агаартай байхаар бэлтгэгдэх,
5. Ус хангамжийн их үүсвэр, эрүүл ахуйн нөхцөлийг бий болгох борооны усыг хуримтлуулах бэлтгэх, ус хадгалах газар, бохир ус болон хатуу хог хаягдалын зохицуулалт, байр сууцны барилгын гүйцэтгэл,
6. Түр байрны хэв маяг материал сонголт нь ч эрүүл ахуй шаардлагатай уялдаж байх хэрэгтэй

Монгол Улсад 2014-2016 онуудад барилга байгууламжийг эрсдэлийн шалгуураар үнэлсэн байдалд дүн шинжилгээ хийхэд орон нутагт ашиглаж байгаа барилгуудын хувьд газар хөдлөлт, барилгын насжилт гэсэн шалгуурууд их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн, нийслэл Улаанбаатар хотод барилгын зориулалт, барилгын байршил, хөрсний нөхцөл, барилгын насжилт гэсэн шалгууруудаар хамгийн их эрсдэлтэй гэж дүгнэгдсэн барилгын хамгийн их байгаа бөгөөд хүн амыг хамгаалах, түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршилд

шаардлагатай нөхцөл байдлыг урьдчилан харж бэлтгэл бэлэн байдлаа хангуулах нь Онцгой байдлын алба, Төрийн удирдлага болон бусад төрийн захиргааны нэгж, хувь хүний хувьд томоохон сорилт болон тулгарч байна.

Монгол Улсад 1990 оноос өмнө хоргодох байр нь гэрлийн цацрагаас бүрэн хамгаалж цохих долгионы үйлчилгээг багасган, нэвтрэх радиацийн үйлчилгээг их хэмжээгээр бууруулж, хордуулах бодисын шингэн туслаас бүрэн хамгаалах ба химийн болон биологийн хордолт, халдвараас хэсэгчлэн хамгаалдаг. Цацрагаас хамгаалах хоргодох байр болгон барилгын подвол, байшингийн шалны доор жижиг зоорь, ногооны агуулах, газар орны агуй, үйлдвэр, орон сууцны байшинг тусгайлан тоног, төхөөрөмжлөн ашиглаж байжээ.

Хоргодох байрны зохион байгуулалтыг товч дурдвал.

1. Хүмүүс байх өрөөнд хэвтэх суухаар төхөөрөмжлөгдсөн,
2. Орц нь нягт хаалгатай, үүдний өрөөтэй, үүдний өрөөний хаалга нь нягт битүүмжлэгдэж, тусгаарлагдсан хамгаалалтын хөшигтэй,
3. Бие засах өрөө,
4. Агаар сорох хоолой,
5. Хучлагын хавтан, шороон хучлага, агаар сорох хоолойн тоосноос хамгаалах шүүгч,
6. Усны хэрэгцээг хангах сав
7. Хүнсний зүйл хадгалах өрөө (Хүнсний зүйл нь 2-оос 3 хоногийн хэрэгцээг хангана)

Эдгээр нь 40-300 хүний багтаамж бүхий зориулалтын хоргодох байрууд байсан бөгөөд эдгээрээс өнөөдрийн байдлаар өмчийн хэлбэр эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн тул зориулалтын бус нөхцөлөөр ашиглагдаж байгаа 6, ашиглаагүй 4, ашиглаж байгаа эсэх тодорхойгүй 1, нийт 11 хоргодох байр байна.Үүнд:

1. Улсын Иргэний хамгаалалтын газрын хоргодох байр, (ОБЕГ)
2. Баянгол дүүгийн 4 дүгээр хороо 5 Б байрны хажууд байрлах хоргодох байр
3. “Талх чихэр” ХК-ны хоргодох байр (Талх чихрийн үйлдвэр)
4. “Сүү” ХК-ны хоргодох байр (Сүүний үйлдвэр)
5. “Сүлжмэл” ХК-ны хоргодох байр (Сүлжмэлийн үйлдвэр)
6. “АПУ”-ны хоргодох байр (архи, пиво, ундааны үйлдвэр)
7. “Монгол нэхмэл” ХК-ны хоргодох байр (Нэхмэлийн үйлдвэр)
8. “WORLD CASHMERE” ХК-ны хоргодох байр (Ноосны үйлдвэр)
9. “Тэц-3”ХК-ны хоргодох байр

10. “Тэц-4”ХК-ны хоргодох байр

11. “Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз”-ийн хоргодох байр Ердийн агааржуулалттай хялбарчилсан хоргодох байрны багтаамж нь 50

хүнээс хэтэрч болохгүй. Хоргодох байранд байхдаа иргэний хамгаалалтын штабаас тогтоосон журмыг хатуу сахиж биелүүлнэ гэх мэт олон шаардлагуудыг тусгасан байдаг.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Эзэмшил, ашиглалтад олгохгүй болон барилга байгууламж барихыг хориглох газрын байршил хэмжээг тогтоох тухай” 114 тоот тогтоолоор томилгоожуулсан хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэр дэх гамшгийн үед иргэд түр цугларах 47 талбай, хотын төвөөс 6 чиглэлд тусгаарлаж нүүлгэн шилжүүлэх 24 байршлын

бэлэн байдлыг хангах зорилгоор судалгаа хийсэн. Судалгаагаар нийслэлийн хүн амын өсөлт, хотын барилгажилттай холбоотойгоор төлөвлөгдсөн томилгоот аюулгүй талбайн газрын хэмжээ багассан, зарим цэгт иргэдийг цуглуулах талбайгүй болсон, өмчийн хэлбэр, эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөн түр цугларах талбайн зориулалтыг өөрчилсөн зэрэг зөрчил дутагдал илэрч байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан шинээр баригдаж буй хороолол, томоохон үйлчилгээний газрын гадна талбай, ногоон байгууламж ашиглан түр цугларах талбайн тоог 64 байршлаар нэмэгдүүлж нийт 111, нүүлгэн шилжүүлэх байршлын тоог 10-аар нэмэгдүүлж нийт 34 байршил болгон тус тус томилгоожуулж, газрын байршил, хэмжээг нарийвчлан тогтоон, цаашид болзошгүй гамшгийн үед иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглахаар тооцоо судалгаа хийн нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Болзошгүй гамшгийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх газрын байршил хэмжээг тогтоох тухай” 94 дүгээр тогтоолоор баталгаажуулсан /Хүснэгт 4/.

Хүснэгт №4. Түр цугларах, нүүлгэн шилжүүлэх байршлын судалгаа

д/д	Дүүрэг	Түр цугларах талбай	Талбай / м ² /	Хүн 2.5 м ²	Нүүлгэн шилжүүлэх байршил	Талбай , га /3.5м ² /	Хүн
1.	Баянзүрх	20	407.500	163.000	4	89	254.285
2.	Баянгол	18	150.100	60.040	3	108	308.570
3.	Сүхбаатар	18	158.100	63.240	5	96	274.285
4.	Сонгинохайрхан	12	72.200	28.880	2	207	591.420
5.	Чингэлтэй	12	60.000	24.000	3	39.8	111.400
6.	Хан-Уул	14	211.000	84.400	2	88	251.421
7.	Багануур	6	434.000	173.600	4	20	57.142
8.	Багахангай	4	19.000	7.600	6	508	100.000
9.	Налайх	7	103.000	41.200	5	136.3	100.000
Нийт дүн		111	1.614.900	645.960	34	1292.1	2048.544

Эх үүсвэр: Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг ... зураг зүйн газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 4-өөс үзэхэд нийслэлийн 9 дүүрэгт гамшиг, ослын үед ард иргэдийн цугларал бий болгох боломжтой 111 байршил буюу нийт 161.49 га талбай байна. Зураг № 5.НИТХТ-ийн 2016 оны 94 дүгээр тогтоол, нүүлгэн шилжүүлэх талбай.

Зураг 5-аас үзэхэд гамшиг ослын үед нүүлгэн шилжүүлэлтийн байршлыг харуулсан байна.

Нийслэл хотод гамшгийн үед түр цугларах талбайг бий болгохдоо цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн талбай, амралтын газруудыг голчлон ашиглах нь тохиромжтой.

Хэрэгжүүлэх арга замууд.

- Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх чухал орон зай нь нийтийн зориулалттай томоохон талбайнуудыг түр цугларах аюулгүй газар болгон ашиглах боломжтойгоор төлөвлөх

- Нийслэл хотын хэмжээнд байрлаж байгаа амралтын газрууд болон нүүлгэн шилжүүлэх байршлын бэлэн байдлыг хангуулах(Хамтарсан гэрээ байгуулах замаар харилцан тохиролцох)

- Түр цугларах талбай, түр байруудын байршлыг тодорхойлсон тэмдэг тэмдэглэгээг тодорхой цэгүүдэд байршуулан ард иргэдэд ойлгомжтой байдлаар схем байршлын зургийг тусгах

- Хүмүүнлэгийн тунхаглал ба гамшгийн хариу үйлдлийн минимум стандартуудыг шаардлагатай түвшинд ашиглах

Олон улсын туршлага, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Олон улсын туршлага, авч хэрэгжүүлж буй хорогдох байрны шийдлийн талаар судлахдаа их анхаарал татсан сонирхолтой жишээгээр Япон Улсын зураглан жишээг авч энэхүү илтгэлдээ орууллаа.

Зураг 6. Япон Улсын бага сургууль, цэцэрлэгийн төлөвлөлт

Япон Улсын гамшгийн үед авах хариу арга хэмжээний тогтолцоо нь олон улсад жишиг болохуйц байдаг. Япон Улс нь сургууль, цэцэрлэгийн барилгад тодорхой норм, дүрэм, стандарт, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан түүнд нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэх ажлуудыг зохион байгуулж байгаа орон юм. Жишээлбэл түр хорогдох байрны зориулалтаар ашиглагдах барилгуудын дэд бүтцийн ажлыг хэвийн үед төвлөрсөн шугам сүлжээнээс хангагдаж гамшиг ослын үед тухайн барилга байгууламж нь өөрийн бие даасан инженерчлэлийн системтэй байхаар зохицуулж цэвэр ус, хэрэглээний ус, цахилгаан бохирын систем, ус цуглуулах технологийг нэвтрүүлэн ажиллаж сургууль бүр усан бассейнтай байхаар төлөвлөж үүгээр түр хорогдох байранд амьдрах иргэдийн хэрэглээний усыг хангахаар төлөвлөсөн байна.

Дүгнэлт

Нийслэлийн нутаг дэвсгэрт үүсч болзошгүй газар хөдлөлт, өнөөгийн нөхцөл байдлын судалгааны дүнгээс харахад

1. Газар хөдлөлтийн эрсдэлийг 9 баллаар тооцож учирч болзошгүй хор уршгаас урьдчилан сэргийлэх төлөвлөлтийг зохион байгуулах

2. Хуучин төлөвлөгдсөн түр хорогдох байрны нөхцөл байдлыг дээшлүүлж засвар үйлчилгээ хийгдэж дахин ашиглагдах боломжтой объектуудыг судлан тодорхойлох

3. Түр хорогдох байранд тавигдах шаардлагыг тодорхой болгож томилгоожуулан заагдсан шаардлагуудыг бүрдүүлэн ажиллах ажил дорвитой ахиц гарахгүй байна.

4. Олон улсад хэрэгжүүлж буй шаардлагад нийцсэн түр хорогдох байрны зохион байгуулалт, барилга байгууламжуудыг судлан ашиглагдаж буй технологийг нэвтрүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг бодлогын хэмжээнд авч үзэн бодит ажил хэрэг болгох нь нэн тэргүүний ажил юм.

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017
2. Улаанхүү.Ч, “Аюулгүй байдлын онолын үндэс”,УБ., 2015,
3. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ, УБ., 2015,
4. “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, “гамшигтай тэмцэх үндэсний чадавхи бэхжүүлэх хөтөлбөр” УИХ-ын 2011оны 22 дугаар тогтоол
5. Онцгой байдлын ерөнхий газрын www.nema.gov.mn цахим хуудас.
6. Батсайхан.В., Хүрэлсүх.С., “Гамшгийн нэр томъёоны тайлбар толь” УБ., 2012,